
**Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших
“Хүнд даацын машин механизмын засварын төв”-ийн
2025 оны байгаль орчны менежментийн
төлөвлөгөө “БАРЛОВОРЛД МОНГОЛИА” ХХК**

“БАРЛОВОРЛД МОНГОЛИА” ХХК

Гарчиг

1	ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3
	Хүчин чадал.....	3
2	БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	5
	2.1.1 Судалгааны талбайн байршил	5
	2.1.2 Судалгааны талбайн уур амьсгалын нөхцөл	5
	2.1.3 Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар.....	6
	2.1.4 Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдол.....	6
	2.1.5 Ургамлан бүрхэвч	7
	2.1.6 Амьтны аймаг.....	8
	2.1.7 Нийгэм-эдийн засгийн нөхцөл.....	9
	2.1.8 Тусгай хамгаалалттай газар	9
3	ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	10
	4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	12
	4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
	4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	15
	4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	16
	4.4. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	18
	4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
	4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	20
5	ДҮГНЭЛТ	22

Зургийн жагсаалт

Зураг 1. Засварын газрын зураг	4
Зураг 2. а. Засвар үйлчилгээний барилга болон задгай агуулах	4
Зураг 3. Төслийн талбайн байршлын тойм зураг	5
Зураг 4. Зүсэлт хийсэн талбайн орчны төрх болон хөрсний зүсэлтийн зураг	6
Зураг 5. NDVI-ийн утга, 2017-2019 он	8

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хүчин чадал	3
Хүснэгт 2. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөллийн тойм	10
Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал	21

1 ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Барловорлд Монголиа” ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших “Хүнд даацын машин механизмын засварын газар” нь “МАК” ХХК-ийн Нарийн сухайтын нүүрсний уурхай болон түүний орчимд байрлах томоохон уул уурхайн компаниудад хүнд даацын машин, механизм нийлүүлэх, түүний засвар үйлчилгээг хангаж ажиллах зорилгоор байгуулагдсан.

Тус төсөл нь сүүлийн жилүүдэд үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 2025 оноос үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байна.

Хүчин чадал

Хүнд даацын машин механизмын засварын газрын засвар, техникийн үйлчилгээний хэсэгт дунджаар 1 хоногт 1-3 машин, 7 хоногт 7-21 хүнд машин механизмд үйлчилгээ үзүүлэх хүчин чадалтай.

Засварын газар нь машины дотоод эд ангийн эвдрэл, гэмтлийг оношлох, хөдөлгүүрийн тос солих, засварлах, явах эд ангийн засвар ба бусад засвар, үйлчилгээг хийдэг.

Хүснэгт 1. Хүчин чадал

№	Технологийн үе шат	Хүчин чадал, ш		
		хоног	сар	жил
1	Цехийн хүчин чадал	2	40	480

Тус засварын газрын нийт талбайн хэмжээ 3.0 га бөгөөд энд засварын газар, ажилчдын байр гэсэн 2 барилгатай. Урд талын хоосон талбай болох задгай агуулахад үйлчилгээнд орсон болон орохоор хүлээгдэж буй, зарж худалдаалж буй машин механизмууд байрладаг.




Зураг 2. а. Засвар үйлчилгээний барилга болон задгай агуулах
б. Ажилчдын байр

2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2.1.1 Судалгааны талбайн байршил

“Барловорлд Монголиа” ХХК-ийн эзэмшлийн 114012 тоот газар ашиглах гэрчилгээтэй талбай нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт “Монголын алт” ХХК-ийн Нарийн сухайтын уурхайгаас хойш 3 км зайд байрлана.



Зураг 3. Төслийн талбайн байршлын тойм зураг

2.1.2 Судалгааны талбайн уур амьсгалын нөхцөл

Судалгааны талбай нь уур амьсгалын тоон ангиллаар Эхийн гол, Өмнөговийн гандуу цөлийн хэсэгт, хуурайдуу халуун зунтай, салхи шуурга ихтэй бүсэд оршино (Гомболүүдэв, 2016); (Доржготов, 2009). Агаарын жилийн дундаж температур $4-6^{\circ}\text{C}$, нэгдүгээр сарын агаарын дундаж температур -16.3°C , долоодугаар сарын агаарын дундаж температур $+20$ -оос 24°C .

Хур тунадасны жилийн дундаж хэмжээ нь нутгийн өмнөд хэсгээр 50мм, төвийн болон хойд хэсгийн ихэнхи нутгаар 100-150мм байна.

Салхины сарын дундаж хурд хаврын улиралд тогтмол их ажиглагддаг ба жилийн дундаж утга 3.7 м/с, салхины хамгийн их хурд 40 м/с хүрдэг бол 15 м/с-

ээс их салхитай өдөр дунджаар 2 өдөр тохиолддог нь салхи шуурга багатайг илэрхийлж байна.

2.1.3 Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар

Гидрогеологийн үндсэн параметрийг Өмнөговь аймгийн гидрогеологийн тулгуур бүтээлүүд болон Өмнөговь аймгийн Усны аж ахуйн байгууллага, судлаачдын 1974-2007 оны хооронд нийт 33 жилийн хугацаанд хийсэн гидрогеологи-геофизикийн судалгааны үр дүнг хүснэгтэд үзүүлэв.

Дээрх үр дүнгээс үзвэл Гурвантэс сумын орчим нь усжилт багатай болох нь харагдаж байна. “Барловорлд Монголиа” ХХК нь өөрийн эзэмшлийн талбайд худаг гаргасан. Худгийн усны чанар нь химийн бүрэлдэхүүнээрээ сульфатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн ерөнхий химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 900:2018”-ын шаардлага хангаж байна.

2.1.4 Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдол

Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Судалгааны талбай болон түүний орчимд умард цөлийн цайвар бор хөрс тархсан байна. Энэ хэв шинжийн хөрс уур амьсгалын халуун, хуурай нөхцлөөс хамааран хөрсний өнгөн хэсэг дээд үеүд хүчтэй халж, ургамлын үлдэгдэл эрдэсжих явц эрчимтэй байдгаас ялзмагт давхарга тод илрэхгүй. Давсны хүчилд гадаргаасаа эхэлж хүчтэй бургиж хөөсөрнө. Энэ хөрс гадаргаасаа эхлээд бүх үе давхарга нь карбонаттай байна. Дээд үедээ ялзмагийн агууламж доод үе давхаргаасаа арай илүү байна.



Зураг 4. Зүсэлт хийсэн талбайн орчны төрх болон хөрсний зүсэлтийн зураг

Судалгааны талбайд тархсан цөлжүү хээрийн цайвар бор хөрс нь хүчтэй шүлтлэг орчинтой, бүх үе давхарга нь карбонатлаг, хөрсний ялзмагийн


агууламж маш бага, дунд зэрэг давсархаг, хөдөлгөөнт фосфорын агууламжаар бага хангамжтай, хөдөлгөөнт калийн агууламж өнгөн хэсэгт бага, гүндээ нэмэгдэж байгаа нь үндэсний хуваарилалттай холбоотой болох нь ялзмагийн агууламжийн зүй тогтолтой ижил байгаа нь харуулж байна.

Хөрсний бохирдолт

Тус эзэмшил газрын хөрсний бохирдлын гол эх үүсвэр нь хог хаягдал, ялангуяа шатах тослох материалын асгаралт юм. Машинд засвар үйлчилгээ хийснээс шатах тослох материал алдагдсан ул мөр хээрийн судалгааны үед ажиглагдаагүй. Хөрсний зүсэлт хийсэн цэгт хөрсний бохирдол байгаа эсэх, хөрсний хүнд металлын фон хэмжээ ямар байгааг тодорхойлох зорилгоор 5-10 см гүнээс дээж авч шинжилгээ хийлгэв. Хөрс судлалын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр хар тугалга, никель, кадми, хөнгөн цагаан, зэс, хром зэрэг элементүүд “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.

2.1.5 Ургамлан бүрхэвч

Судалгаа гүйцэтгэсэн нутаг нь Азийн цөлийн мужийн, Төв-Говийн цөлийн хошуу, Алашаагийн говийн тойрог, Эзний гол орчмын тойрогт хамрагдана (Юнатов, 1977). Судалгаа гүйцэтгэсэн нийт талбайн хэмжээнд бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг гаргахад нийт 10 овгийн 22 төрлийн 28 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд тагдгар мод-1, сөөг-7, сөөгөнцөр-4, сөөгөнцөрлөг-5, олон наст өвс-10, хоёр наст-1 зүйл ургамал тус тус тэмдэглэгдсэн. Судалгааны талбайн эргэн тойрон дахь бэлчээр нутаг нь жилийн дөрвөн улиралд ашиглах боломжтой ба ялангуяа хавар, намрын бэлчээрт ашиглахад илүү тохиромжтой бэлчээрийн газар. Сүүлийн 3 жилийн NDVI-ийн явцаас үзвэл дундаж -0.037-0.108, стандарт хазайц 0.0069-0.034 байна. 2019 онд NDVI-ийн утга эрс нэмэгдсэн байгаа нь зуншлагатай сайн байсантай холбоотой юм. Оронзайн ялгаа ихтэй болох нь вариацийн итгэлцүүр 0.18-0.31 байгаагаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөнөөс ургамлан бүрхэвчийн өөрчлөлтийн ялгаа их байгааг харуулна.



Зураг 5. NDVI-ийн утга, 2017-2019 он

2.1.6 Амьтны аймаг

Гурвантэс сум нь тус аймгийн хамгийн том сумдын нэг ба Говь гурван сайхан байгалийн цогцолборт газар хэсэгчлэн ордог. Тус суманд байгаль, түүх, соёлын чухал ач холбогдолтой газруудыг хамгаалах зорилгоор байгуулагдсан таван орон нутгийн тусгай хамгаалалттай газар байдаг.

Гурвантэс сумын нутаг дэвсгэр төрөл бүрийн амьдрах орчны хэв шинжтэй, сумын хойд хэсгээр Алтайн уулс, нутгийн өмнөд хэсэгт заримдаг говь цөл оршдог. Олон ховор болон ховордсон зүйл энэ суманд байдаг. Гурвантэс сумын нутагт бүс нутгийн хэмжээнд ховордсон болон ховордож болзошгүй зүйлүүд байдаг. Тухайлбал: ооч ёл (VU), нөмрөг тас (LC), идлэг шонхор (VU), зээрд шонхор (LC), жороо тоодог (VU), монгол хулаг жороо (VU), загийн боршувуу (NT), соотон атигдаахай (EN), таван хуруут атигдаахай (DD), өөхөн сүүлт атигдаахай (DD), говийн атигдаахай (DD), одой атигдаахай (DD), гозоорой зурам (EN), бордуу шишүүхэй (DD), цагаан зээр (EN), хулан адуу (EN), хар сүүлт зээр (VU), шилүүс мий (NT), цоохор ирвэс (EN), мануул мий (NT), цоохондой мий (NT), саарал чоно (NT), хярс (NT), шар үнэг (NT) зэрэг болно. Жороо тоодог, монгол хулан жороо, загийн боршувуу, ооч ёл, соотон атигдаахай, одой атигдаахай, гозоорой зурам, хулан адуу, хар сүүлт зээр, цоохондой мий, цоохор ирвэс, шилүүс мий зэрэг нь Монгол улсын улаан номонд орсон байна. Мөн Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт Монгол оронд байгаа зарим зүйлийн мөлхөгч амьтдын хувьд нэн чухал газар юм (Нямбаяр & Ганхуяг, 2015).

2.1.7 Нийгэм-эдийн засгийн нөхцөл

Сумын хүн амын нягтшил 0.16 хүн/км.кв байгаа нь Өмнөговь аймгийн бусад сумуудтай харьцуулахад бага нягтшилтай байна.

Сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй, уул уурхай. Сумын төвд төсөвт 6 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3 үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна холбооны салбар, ХААН банк, Төрийн банк, Капитрон банк, Гялс төгрөг хадгаламж зээлийн хоршоо, цаг уур, шуудан холбоо, Өмнөд бүс цахилгаан түгээх сүлжээ ХХК, НИК ШТС, Хөрс ШТС, МТ ШТС зэрэг хувийн хэвшлийн байгууллагууд ажиллаж байна. Сумаас 55 км-т орших Дундголын давсны уурхайгаас “Говь гурван сайхан ХХК”, “Асралт ХХК”, “Сондог нөхөрлөл” нь жилдээ 220 орчим тн давс олборлож борлуулдаг ба сумаас 25 км-т орших Чин-Хуа Мак, Мак, Нарийн сухайт ХХК, Монголын алт МАК ХХК, Саусгоби сэндс ХХК, Өсөх зоос ХХК, Жавхлант орд ХХК-ууд нүүрс олборлон БНХАУ-д экспортолж байгаа бөгөөд Алтны АГМ майнинг ХХК, хайрганы Чухамжаргалан ХХК, чулууны Баатарван транс ХХК, Өмнийн говийн баялаг ХХК үйл ажиллагаа явуулж байна.

Сумын цэцэрлэгийн 3 байранд жилдээ 300 орчим гаруй хүүхэд хүмүүжиж, 15 ортой хүн эмнэлэг, 250 суудалтай Соёлын төв, номын сан, 16 хүний бүрэлдэхүүнтэй Цагдаагийн тасаг ажиллаж байна. 2005-2006 оны хичээлийн жилээс 8 жилийн дунд сургууль 11 жилийн сургалттай сургууль болон өргөжин бөгөөд хичээлийн 3 байранд нийт 70 багш ажилчид ажиллаж, 1017 хүүхэд суралцаж байна. Мөн тус сумын нутагт хилийн цэргийн 0166 дугаар анги байрладагаас гадна “Шивээ хүрэн”-ийн хилийн боомт үйл ажиллагаа явуулж байна.

Холбоо харилцааны хувьд мобиком, скейтейл, юнител, жимобайл зэрэг үүрэн телефон суурилагдан, хүн амын 100 хувь нь гар утас хэрэглэж байна. БНХАУ-ын ӨМӨЗОрны хөрш аймгаас өндөр хүчдэлд холбогдсон, 24 цагийн гэрэл цахилгаантай.

Гурвантэс сумын нутаг дэвсгэрийн хэмжээ 2,799,957.80 га бөгөөд 26.07 хувийг хөдөө аж ахуйн газар, 72.02 хувийг тусгай хэрэгцээний газар, 1.56 хувийг ойн сан бүхий газар, 0.41 хувийг хот суурин газар, 0.27 хувийг зам шугам сүлжээний газар, 0.05 хувийг усны сан бүхий газар тус тус эзэлж байна. Улсын тусгай хэрэгцээний газраас бусад ангиллын газрын эзлэх талбайн хэмжээ 783,340.98 га бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 27.98 хувийг эзэлж байна.

2.1.8 Тусгай хамгаалалттай газар

Судалгааны талбай нь Говийн их дархан газраас 192 км, бага дархан газраас 407 км, Говь гурван сайханы БЦГ-аас 50 км зайд оршино.

3 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлохдоо НҮБХХБ болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны хамтран хэрэгжүүлж буй Монгол улсын Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд боловсруулсан аргачлал, БОАЖЯ-ны сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 тушаалаар батлагдсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлал” зэргийг ашиглан дээрх бүлгүүдэд гүйцэтгэгдсэн тооцоо, судалгаа, үнэлгээний дүнг нэгтгэн тооцоолсон болно. Сөрөг нөлөөллийг доорх зурагт үзүүлсэн схемийн дагуу тодорхойлсон.

Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдийг жагсаахдаа байгаль орчны үндсэн 4 бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилан хүснэгтийн 2-р багана, 2-р мөрөөс эхлэн багана тус бүрд нэг нэгээр нь бичив. Тус төслийн үйл ажиллагаа байгаль орчны аль бүрэлдэхүүн хэсэгтэй харилцан үйлчлэлцэхийг хүснэгтэд тэмдэглэхдээ сөрөг нөлөөлөл үзүүлбэл х, нөлөө үзүүлэхгүй бол 0, эерэг нөлөөлөл үзүүлбэл + тэмдэг зэргийг ашиглав.

Хүснэгт 2. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөлөөллийн тойм

Байгаль орчны элементүүд										
№	Төслийн үйл ажиллагаа	Агаарын чанар	Гадаргын усны чанар, нөөц	Газрын доорх усны нөөц, чанар	Ургамлан нөмрөгийн талхагдал	Амьтны аймаг	Хөрсний хими физик шинж чанар	Геологийн тогтоц	Нийгэм-эдийн засгийн нөхцөл	нийт дүн
1	Ахуйн хог хаягдал	х	0	0	х	0	х	0	0	3
2	Ахуйн бохир ус	0	0	х	х	0	х	0	0	3
3	Засварын төв	х	0	0	х	0	х	х	+	4
4	Шатах тослох материал хэрэглээ	х	0	х	х	0	х	0	+	4
5	Унд ахуйн ус хэрэглээ	0	0	х	0	0	0	0	х	2
6	Хүн, машин техникийн хөл хөдөлгөөн	х	0	0	х	х	х	0	+	4
7	Нийт дүн	5	0	3	5	1	6	1	1	

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тоогоор нь жагсаавал хүн, машин техникийн хөл хөдөлгөөнөөс шалтгаалсан хөрс, ургамлан бүрхэвчийн элэгдэл, ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаас шалтгаалсан хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгийн бохирдол, шатах тослох материалын ашиглалт, хадгалалтаас үүсэж болзошгүй хөрсний

бохирдол бөгөөд нөлөөллийн эрчмийн хувьд бага байна. Энд зөвхөн нөлөөллийн тоогоор жагсааж байгаа болно. Эдгээр нөлөөлөл нь сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авбал буурах боломжтой нөлөөлөл юм.

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчин-эдийн засаг

Энэхүү төслийн үйл ажиллагаа нь МУ-ын ЗГ-ын мөрийн хөтөлбөр, Бүс нутгийг хөгжүүлэх бодлого, засаг захиргааны нэгжийн хөгжлийн хөтөлбөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигт тусгагдсан үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулна. Улс орны эдийн засагт дараах хэлбэрээр хувь нэмэр оруулна.

- Ашгийн татвар
- Хүн амын орлогын албан татвар
- Нийгмийн л шимтгэл
- Газар ашигласны төлбөр
- Ус ашигласны төлбөр
- Байгалийн нөөц баялаг ашиглахтай холбогдох татвар, төлбөрүүд

Мөн байгаль орчныг хамгаалах зардлыг жил бүр үндсэн үйл ажиллагааны төсөвт тусгаснаар БОХТ ба ОХШХ-т тусгагдсан арга хэмжээнүүд хэрэгжинэ.

Байгаль орчин-удирдлага зохион байгуулалт

Төсөл хэрэгжүүлэгч “Барловорлд Монголиа” ХХК нь байгаль орчны мэргэжилтэн эсвэл мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллана. Ингэснээр байгаль орчны календарьчилсан төлөвлөгөө гаргаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компанийн удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Байгаль орчны бодлого, зорилго

“Барловорлд Монголиа” ХХК нь экологи-эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх байгаль орчны бодлогоо дараах хэлбэрээр тодорхойлсон.

- Компанийн бүхий л үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах асуудал нь чухал ач холбогдолтой байна.
- Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх, байгаль орчны үзүүлэлтүүдийг сайжруулах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинд учруулах нөлөөллүүдийг хүрч болох хамгийн бага түвшинд байлгахаар хянана.
- Компанийн байгаль орчны бодлого, зорилт, хэрэгжилт, тэдгээрийн үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байна.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Бохир ус	Бохир ус цэвэршүүлэх төхөөрөмжөөс гарч буй саарал уснаас дээж авч шинжлүүлэх, MNS 4943:2015 стандартын шаардлага хангаж буй эсэхийг тодорхойлох	Цэвэршүүлсэн бохир ус	удаа	4	130.0	520.0	Жилд 2 удаа	Усны тухай хууль MNS 4943:2015 MNS 6148:2010
	"Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах	Бохир ус	ш	1	46.0	46.0	2-3-р улирал	"Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"
Хөрс, ургамал бохирдох, нэвчилт явагдах	Хог хаягдал түр хадгалах цэгийн доорх талбайг нэвчилт, шүүрэлт явагдахааргүй хатуу хучилттай болгох	Газрын доорх ус, хөрсний чанар	м ²	50	5.0	50.0	2-р улирал	Хог хаягдлын тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Хөрс, ургамлан нөмрөг талхлагдах	Техник хэрэгслийн засвар, тос солих үйлчилгээг зөвхөн хатуу хучилттай талбайд хийх	Засварын газар	-	-	-	-	Тогтмол	MNS 5850:2019
Хөрс,	Гадаад тээврийн зам буюу	2.3 км шороон	ш	50	2.0	100.0	3-р улирал	MNS 4597:2014

ургамлан нөмрөг талхлагдах	Нарийн сухайтын замаас засварын төв хүртэлх 2 км урттай шороон замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх	зам						
Шатах тослох материалаар хөрс бохирдох	Шатах тослох материал хөрсөнд алдагдсан тохиолдолд шингээх асгаралтын иж бүрдэл бэлэн байлгах	Хөрс хамгаалал	иж бүрдэл	1	-	-	Тогтмол	MNS 5850:2019
Нийт, мян.төг						716.0		

4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	- Тэрбум мод үндэсний хөдөлгөөн болон орчны тохижилтын хүрээнд мод тарьж ургуулах	100 ш мод тарих	Өөрийн эзэмшил талбайд	ш	100	15.0	1,500,000	5, 10 сар	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
2	Нийт, мян.төг						1,500,000		

4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Энгийн хог хаягдал	Шаардлагатай газруудад цаас, хуванцар сав, шил лааз, гялгар уут, тостой хаягдал, бусад г.м ангилал бүхий хогийн савнууд байрлуулах	Засварын газар, ажилчдын байр	ш	150.0	2	300	2-р улирал	Хог хаягдлын тухай хууль
	Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах - Төмрийн хаягдал - Цаасны хог хаягдал - Гялгар уутны хаягдал - Хуванцар хаягдал - Ерөнхий хаягдал - Модны хаягдал - Хоол хүнсний хаягдал - Шил, лааз, ундааны сав г.м	Бүх хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
	Ахуйн хог хаягдал түр хадгалах цэгийг стандартын дагуу барьж байгуулах		ш	1	150	150	2-р улирал	“UCS1701A Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент”-

								ын дагуу хог хаягдал түр хадгалах цэг байгуулах
	Энгийн хог хаягдлыг сумын ТҮК-ээр зайлуулах /гэрээ сунгах/	Хөрс бохирдох	тн	-	-	Гэрээний дагуу	Сард 1-2 удаа	Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2011
Аюултай хог хаягдал	Ашигласан тос, тосолгооны материал, тостой даавуу гэх мэт аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Хөрс бохирдуулах	-	-	Гэрээний дагуу	“Хай би Ойл” ХХК	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль Засгийн газрын 116-р тогтоол
	Хаягдал аккумуляторыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах	Хаягдал аккумулятор	ш	“Үлэмж хүдэр” ХХК-д			Жил бүр	
	Хаягдал дугуйг 2-догч түүхий эд авах цэгт тушаах, тушаах, боломжгүйг холбогдох журмын шаардлага хангасан нөхцөлд өөрийн талбайд түр хадгалах	Хаягдал дугуй		“Ханбогд инвестмент” ХХК-д нийлүүлэх			Жил бүр	
	Хаягдал батарейг өөрийн талбайд хадгалах	Бүх батарей	ш	-	-	Өөрийн талбайд түр хадгалах	Тогтмол	
Нийт, мян.төг						450.0		

4.4. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Хөрсөн бүрхэвч	- Агрохими - Хүнд металл /Pb, Cd, Hg, As, Cr,.../	- Хаягдал тос хадгалах талбай - Хогийн цэг	Жилд 1 удаа	55.0	110.0	MNS 5850:2008 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Ус	- Хүнд металл - Ерөнхий үзүүлэлт	- Худгийн ус	Жилд 1 удаа	46	230.0	MNS 4943:2015 MNS 900:2018 Усны тухай хууль
		- Цэвэршүүлсэн бохир ус	Улиралд 1 удаа			
Нийт зардал, мян.төг					440.0	

4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Ус ашиглуулах дүгнэлтийг аймгийн байгаль орчны газраар гаргуулах	50.0	2-р улирал	БО-ы мэргэжилтэн	Усны тухай хууль
2	Сумын ЗДТГ-тай Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулах	-	2-р улирал	Захирал	Усны тухай хууль
3	Сав газраар Хаягдал усны дүгнэлт гаргуулах	-	1-р улирал	БО-ы мэргэжилтэн	Усны тухай хууль
4	Нийт зардал, мян.төг	50.0			

4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Аймаг болон сумын БОГ-т БОМТ-ий биелэлтийн тайланг танилцуулах	3% хэвлэмэл болон цахим хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ий хүрээнд, мөн байгаль хамгаалах чиглэлээр хийсэн нэмэлт ажлуудын тухай	11 дүгээр сарын 1	-	Захирал, менежер, БО-ы мэргэжилтэн	Өмнөговь аймгийн БОАЖГ
2	Нийт зардал, мян.төг				-		

Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал

№	Арга хэмжээ	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө	716.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1 500.0
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	450.0
4	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	50.0
5	Орчны хяналт шинжилгээ	440.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	-
	Нийт зардал, мян.төг	3 156.0

5 ДҮГНЭЛТ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших “Хүнд даацын машин механизмын засварын төв” төслийн 2025 оны орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 3156.0 мян.төг болно.